

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЧАНДМАНЬ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/64/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар  
Утас: 70433061  
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn  
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн  
Утас: 70432545  
Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn  
Гэрээт аудитор: Б.Бадамцэцэг  
Утас: 70432545  
цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ТБОНӨХБАҮХАТ</i>	<i>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын дамгын газар</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<i>БҮТЭЗ</i>	<i>Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл</i>
<i>ИТХ</i>	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>

Агуулга

<b>1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/ .....	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/ .....	6
2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/ .....	8
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	10
/төгрөгөөр/.....	10
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/.....	10
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН .....	12
<b>3.АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>12</b>
3.1. Ерөнхий зүйл .....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	13
3.4. Материаллаг байдал .....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа:Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд: .....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	17
Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 5340.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав. ....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18
Аудитаар материаллаг хэмжээний алдаа зөрчил илэрсэн тул тус байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалтай дүгнэлт өгч, ТТЗ-ын тайлангаар сахилгын шийтгэл ноогдуулах асуудлыг авч үзэх шаардлагатай.....	18
<b>4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....</b>	<b>18</b>
<b>5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>19</b>

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ЧАНДМАНЬ СУМЫН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
З.ЛХАГВА ТАНАА

2021-02-18 № 4/55  
танай \_\_\_\_\_ -нм № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурьдсан алдаа зөрчлийг эс тооцвол Чандмань сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлэгдээгүй тул хязгаарлалттай санал, дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Чандмань сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан

921020292

бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### **Аудитын гол асуудал**

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зарим зардлыг зориулалт бусаар зарцуулсан, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, үр дүнгийн урамшууллыг ажлын үр дүнтэй уялдуулан дүгнээгүй, Шилэн дансны хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээллээгүй зэрэг зөрчлүүд "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал", "оршин байх", "толилуулга ба тодруулга", "тохиолдсон байх", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>19,374,030.50</u></b>	<b><u>22,431,050.09</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	292,115.00	268,747.19
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	292,115.00	268,747.19
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	500,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	-	500,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	500,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	19,081,915.50	21,662,302.90
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	1,636,500.00
35130	Эм боох материал	-	1,636,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	19,081,915.50	20,025,802.90
35410	Бичиг хэргийн материал	-	35,000.00
35420	Аж ахуйн материал	9,310,123.50	12,950,623.50
35440	Түлш, шатах тослох материал	1,200,000.00	1,200,000.00
35450	Барилгын засварын материал	-	500,000.00
35460	Хүнсний материал	8,571,792.00	5,340,179.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>786,045,121.12</u></b>	<b><u>765,919,032.83</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	786,045,121.12	765,919,032.83
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	771,961,521.12	751,949,682.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	773,810,440.00	773,810,440.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(34,850,104.02)	(54,568,030.98)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,541,674.00	75,970,697.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(64,239,702.92)	(63,695,644.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,697,842.82	45,456,066.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,669,606.76)	(27,694,823.53)
39217	Ном	2,670,978.00	2,670,978.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	14,083,600.00	13,969,349.92
39301	Програм хангамж	587,000.00	587,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(130,000.00)	(244,250.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,626,600.00	13,626,600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>805,419,151.62</u></b>	<b><u>788,350,082.92</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>358,000.00</u></b>	<b><u>170,412.73</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	358,000.00	170,412.73
<b>413</b>	<b>Өглөг</b>	358,000.00	170,412.73
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	121,312.73
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	358,000.00	49,100.00

41361	Байгууллагад төлөх өглөг	358,000.00	49,100.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>805,061,151.62</b>	<b>788,179,670.19</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	805,061,151.62	788,179,670.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,972,543.00	190,972,543.00
51101	Өмч: - төрийн	190,972,543.00	190,972,543.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	256,755,621.66	239,991,177.60
51210	Өмнөх үеийн үр дүн	256,755,621.66	256,872,659.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	(16,881,481.43)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	357,332,986.96	357,215,949.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>805,419,151.62</b>	<b>788,350,082.92</b>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>282,002,585.00</b>	<b>343,588,113.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,704,985.00</b>	<b>7,895,613.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,704,985.00	7,895,613.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,704,985.00	7,895,613.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,704,985.00	7,895,613.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>276,297,600.00</b>	<b>335,692,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	262,491,600.00	302,397,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	262,491,600.00	302,397,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	13,806,000.00	33,295,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,806,000.00	33,295,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>306,579,653.20</b>	<b>359,352,265.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>306,579,653.20</b>	<b>359,352,265.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	306,579,653.20	334,456,965.67
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	182,362,134.20	224,233,081.00

210101	Үндсэн цалин	182,362,134.20	221,683,581.00
210102	Нэмэгдэл	-	2,549,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,009,868.15	27,075,847.69
210201	Тэтгэврийн даатгал	15,724,022.35	18,433,687.51
210202	Тэтгэмжийн даатгал	1,821,461.45	2,159,149.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,457,169.15	1,737,192.02
210204	Ажилгүйдлийн даатгал	364,292.30	449,387.78
210205	Эрүүл мэндийн даатгал	3,642,922.90	4,296,430.74
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,416,800.00	32,400,552.00
210301	Гэрэл, цахилгаан	2,151,368.00	1,709,800.00
210302	Түлш, халаалт	18,920,182.00	30,602,900.00
210303	Цэвэр, бохир ус	345,250.00	87,852.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,123,750.00	2,027,450.00
210401	Бичиг хэрэг	397,750.00	1,179,058.00
210402	Тээвэр, шатахуун	632,000.00	754,192.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	80,200.00
210404	Ном, хэвлэл	44,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,200.00	14,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	41,031,318.00	20,851,912.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,000.00	2,168,400.00
210502	Хоол, хүнс	41,008,318.00	18,683,512.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	1,494,500.00
210604	Урсгал засвар	-	1,494,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	101,100.00	101,100.00
210702	Дотоод албан томилолт	101,100.00	101,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	200,000.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	37,534,682.85	26,072,522.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,426,596.09	272,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	479,500.00	420,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,628,586.76	25,379,372.38
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	24,895,299.85
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	24,895,299.85
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24,895,299.85
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(24,577,068.20)</b>	<b>(15,764,152.52)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	1,117,328.91
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,117,328.91
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(1,117,328.91)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(24,577,068.20)</b>	<b>(16,881,481.43)</b>

2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>276,297,600.00</b>	<b>340,766,954.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>276,297,600.00</b>	<b>340,766,954.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	262,491,600.00	302,397,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	262,491,600.00	302,397,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	13,806,000.00	33,295,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,806,000.00	33,295,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	5,074,454.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		5,074,454.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>276,297,600.00</b>	<b>340,766,954.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>276,297,600.00</b>	<b>340,766,954.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>276,297,600.00</b>	<b>310,797,200.15</b>

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	186,862,426.00	222,905,590.38
210101	Үндсэн цалин	115,465,541.00	144,800,668.30
210102	Нэмэгдэл	47,573,800.00	62,365,569.78
210104	Урамшуулал	12,720,485.00	15,739,352.30
210105	Гэрээт ажлын хөлс	11,102,600.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,781,574.00	28,742,657.77
210201	Тэтгэврийн даатгал	15,887,393.00	22,055,538.42
210202	Тэтгэмжийн даатгал	1,971,200.00	1,794,231.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,577,600.00	1,246,276.51
210204	Ажилгүйдлийн даатгал	532,374.00	310,412.88
210205	Эрүүл мэндийн даатгал	3,813,007.00	3,336,198.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,847,432.00	32,983,052.00
210301	Гэрэл, цахилгаан	2,335,000.00	2,292,300.00
210302	Түлш, халаалт	11,167,182.00	30,602,900.00
210303	Цэвэр, бохир ус	345,250.00	87,852.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	952,400.00	2,349,200.00
210401	Бичиг хэрэг	97,700.00	97,700.00
210402	Тээвэр, шатахуун	632,000.00	708,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	80,200.00
210404	Ном, хэвлэл	44,800.00	55,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	177,900.00	1,406,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	48,023,468.00	20,142,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,300.00	2,207,300.00
210502	Хоол, хүнс	47,475,968.00	17,000,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	495,200.00	935,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	142,200.00	113,800.00
210604	Урсгал засвар	142,200.00	113,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	101,100.00	101,100.00
210702	Дотоод албан томилолт	101,100.00	101,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	136,000.00	327,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	136,000.00	127,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,451,000.00	3,131,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,474,500.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	976,500.00	3,131,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>29,969,753.85</b>

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	5,074,454.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		5,074,454.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	24,895,299.85
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	24,895,299.85

**2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	190,972,543.00	357,332,986.96	256,755,621.66	805,061,151.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>190,972,543.00</b>	<b>357,332,986.96</b>	<b>256,755,621.66</b>	805,061,151.62
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>190,972,543.00</b>	<b>357,332,986.96</b>	<b>256,755,621.66</b>	805,061,151.62
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>190,972,543.00</b>	<b>357,332,986.96</b>	<b>256,755,621.66</b>	805,061,151.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(117,037.37)	117,037.37	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>190,972,543.00</b>	<b>357,215,949.59</b>	<b>256,872,659.03</b>	805,061,151.62
D08	Тайлант үеийн үр дүн			(16,881,481.43)	(16,881,481.43)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>190,972,543.00</b>	<b>357,215,949.59</b>	<b>239,991,177.60</b>	788,179,670.19

**2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	310797200.15	310797200.15
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	310797200.15	310797200.15
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	310797200.15	310797200.15
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	222200080.38	222905590.38
210101	Үндсэн цалин	139206741.30	144800668.30
210102	Нэмэгдэл	67253986.78	62365569.78
210104	Урамшуулал	15739352.30	15739352.30
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос НДШ</b>	29448167.77	28742657.77

210201	Тэтгэврийн даатгал	22761048.42	22055538.42
210202	Тэтгэмжийн даатгал	2283931.66	1794231.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	756576.51	1246276.51
210204	Ажилгүйдлийн даатгал	310412.88	310412.88
210205	Эрүүл мэндийн даатгал	3336198.30	3336198.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32983052.00	32983052.00
210301	Гэрэл, цахилгаан	2292300.00	2292300.00
210302	Түлш, халаалт	30602900.00	30602900.00
210303	Цэвэр, бохир ус	87852.00	87852.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2349200.00	2349200.00
210401	Бичиг хэрэг	97700.00	97700.00
210402	Тээвэр, шатахуун	708800.00	708800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	80,200.00	80,200.00
210404	Ном, хэвлэл	55,800.00	55,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,406,700.00	1,406,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	20,142,900.00	20,142,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,207,300.00	2,207,300.00
210502	Хоол, хүнс	17,000,400.00	17,000,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	935,200.00	935,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	113,800.00	113,800.00
210604	Урсгал засвар	113,800.00	113,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	101,100.00	101,100.00
210702	Дотоод албан томилолт	101,100.00	101,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	327,600.00	327,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127,600.00	127,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,131,300.00	3,131,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,131,300.00	3,131,300.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	335,692,500.00	310,797,200.15
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	302,397,300.00	277,502,000
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	302,397,300.00	277,502,000
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	33,295,200.00	33,295,200.00

132001	Орон нутгийн төсвөөс	33,295,200.00	33,295,200.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	1.00	1.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	1.00	1.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>20.00</b>	<b>19.00</b>
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	12.00	11.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00
650010	Гэрээт ажилтан	2.00	2.00

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,074,454.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,074,454.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,074,454.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,074,454.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,074,454.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	5,074,454.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	5,074,454.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,074,454.00

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Чандмань сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч З.Лхагва танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримт бүрдүүлэлт, шатахууны зарцуулалт, хүүхдийн хоол хүнс, үдийн цай хөтөлбөрийг тендер зарлан, гэрээ байгуулан шалгаруулж бэлтгэх, талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 9-нээс 2021 оны 02 дугаар сарын 17-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Бадамцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Чандмань сумын цэцэрлэг нь “эрүүл аюулгүй тохилог орчинд сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулахын төлөө хамтдаа хамтарч ажиллах, боловсролын шинэчлэлийн бодлоготой уялдуулан сургалт хүмүүжлийн ажлаа төлөвлөх, багшаа чадваржуулах” -д оршино гэж тодорхойлжээ.

Чандмань сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох
- хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох;
- хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах;
- хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 450 тоот “Хоолны зардлын норматив тогтоох тухай”

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Чандмань сумын Цэцэрлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 оны санхүүгийн баримтад дотоод хяналт хийгдээгүй байна. Сумын санхүүгийн албанаас дотоод аудитын нэгжтэй боловч хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан ирүүлээгүй болно.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 283966,1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 2839,7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 343588.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3435.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Чандмань сумын цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17069.1 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	292.1	768.7	476.6
БАРАА МАТЕРИАЛ	19081.9	21662.3	2580.4
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	786045.1	765919.0	(20126.1)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>805419.1</b>	<b>788350.1</b>	(17069.1)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	358.0	170.4	(187.6)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	805061.1	788179.7	(16881.5)
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>805419.1</b>	<b>788350.1</b>	(-17069.1)

Авлага дансны үлдэгдэл 292.1 мянган төгрөг болж 476.6 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь урьдчилгаа олгоод суутган тооцоо хийгээгүйтэй холбоотой ба энэ авлага нь бүрэн барагдах боломжтой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 21662.3 мянган төгрөг болж 2580.4 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй бараа материал ирснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 786045.1 мянган төгрөг, оны эцэст 788350.1 мянган төгрөг болж 17069.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 5070.6 мянган төгрөгөөр зөөврийн компьютер, буузны жигнүүрийг хандиваар авч, 1300.0 мянган төгрөгийн үнэтэй буузны жигнүүр зөвшөөрөлгүй бэлтгэж нийт 6370.6 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр оны эхэнд 358.0 мянган төгрөг оны эцэст 170.4 мянган төгрөг болж 187.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 190972.5 мянган төгрөг болж тайлант онд өөрчлөлтгүй байна.

Чандмань сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 61585.5 мянган төгрөгөөр буюу 21.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 61585.5 мянган төгрөгийн орлогоос 39905.7 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 19489.2 мянган төгрөгөөр орон нутгийн хөгжлийн санхүүжилт, үнэ төлбөргүй орлого 2190,6 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 52772.7 мянган төгрөгөөр буюу 14.6 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 45937.0 мянган төгрөг буюу 33.6 хувиар өссөн, тогтмол зардал 10983.8 мянган төгрөг буюу 51.2 хувиар, хангамж бараа материалын зардал 903.8 мянган төгрөг буюу 44.5 хувиар өссөн, норматив зардал 20179.4 мянган төгрөг буюу 96.7 хувиар, бараа үйлчилгээний зардал 11462.2 мянган төгрөг буюу 43.9 хувиар дээрх зардлууд буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн, ковид- 19 цар тахалтай холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 335692.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 335692.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 335692.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 33295.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 302397.3 мянган төгрөгийг Улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 302397.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 33295.2 санхүүжилт авч, нийт 335692.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 310797,2 мянган төгрөгийг зарцуулж 24895.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 5 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 25009.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой цалин, нийгмийн даатгалын шимтгэл, халаалтын зардал, хоол хүнс арга хэмжээний зарцуулах эрхийг нээж өгөөгүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	10688.8
80109	ТШЗ-ийн тогтмол зардал	312.1
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	6794.1
81831	Ээлжийн бүлэгт хамруулах	5648.7
81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	1565.3
	<b>ДҮН</b>	<b>25009.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар НДХ-ээс 2 хүний жирэмсэн амаржсаны тэтгэмжийн орлого 5074.4 мянган төгрөгийн тэтгэмжийг дамжуулан зарцуулжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 21 мэдээллээс хугацаандаа оруулсан 17 мэдээллийг оруулсан боловч 4 мэдээллийг цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээнд санхүүжилтийн мэдээллийг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын мэдээлэлд санхүүжилтийг мэдээлэхдээ 10 дугаар сарын мэдээллийг мэдээлээгүй, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8540.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжээгүй байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	2	8540.4	0	0	2	8540.4	0
Нийт дүн	2	8540.4	-	-	2	8540.4	0

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 46286.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 32546.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 8400.2 мянган төгрөгийн төлбөрийн акт бичиж, 1777,2 мянган төгрөгийг буцаан олгох акт бичиж, 5340.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа:** Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүжилтийн орлогыг бусад орлого гэсэн үзүүлэлтийг сонгосонтой холбоотой 27355,0 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг өсгөн тайлагнасан,
2. Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжин олгосон 2 хүний жирэмсэн амаржсаны тэтгэмж 5074,4 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаагүй байсныг,
3. Үндсэн хөрөнгө актлахдаа дахин үнэлгээний зөрүүг тооцоогүй зөрүү 117.0 мянган төгрөгийг аудитын явцад залруулга хийгдлээ.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 32546.5 мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 10177.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 10177.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

**Төлбөрийн акт 1.** Тухайн байгууллага нь тайлант онд ажилчдадаа түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо нярвын дансаар дамжуулж зарим хүмүүст дутуу олгож, зарим хүмүүст илүү олгосонтой холбоотой 1777.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Иж бүрэн, Үнэлгээ, Хэмжилт, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** *Төлбөрийн акт тогтоож, нэр бүхий албан хаагчдаас төлүүлж, нэр бүхий албан хаагчдад буцаан олгох.*

**Төлбөрийн акт 2.** Тайлант онд ажилчдад цалингийн сангаас нэгжийн үнэ олгосон, үр дүн, ур чадварын нэмэгдэл илүү олгосон, ажилчдадаа тараасан хүнсний материалын үнэ суутган тооцоо хийгээгүй, авлагаар бүртгээгүй, шууд зардалд бүртгэсэн, 24 цагийн жижүүрлэсний урамшуулал олгохдоо нярвын дансаар дамжуулж, албан хаагчдын дансанд бүрэн шилжүүлж олгоогүй, шатахууны тооцоо хийгээгүй анхан шатны баримтын бүрдэлгүй шууд зардалд бичсэнтэй холбоотой 4890.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Иж бүрэн, Үнэлгээ, Хэмжилт, Үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д “төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Сангийн сайдын 2019 оны 03-р сарын 27-ны 74 тоот тушаалын 2.2.4-д “Төсвийн зарлагын хэмнэлтийг зарцуулах санал /төсвийн тухай хуулийн 46.3.2, 46.3.3-т заасан арга хэмжээнд зарцуулах бол байгууллагын хамт олны хурлын тэмдэглэл, хуралдааны шийдвэрийн хамт/ гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов.

**Төлбөрийн акт 3.** Тайлант онд багш ажилчдад түлээ нүүрсний хөнгөлөлтөд цалингийн зардлаас 7220.0 мянган төгрөгийг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэлийг даатгуулагчаас суутган аваагүй, ажил олгогчоос төлөх шимтгэлд нийт 1732.8 мянган төгрөгийг төлөөгүй, 2020 оны 12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд тусгаагүй орхигдуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-д "аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого"-д нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын тайланг дахин илгээж нийт албан хаагчдад олгосон түлшний хөнгөлөлтөөс 1732.8 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**Аудитын зөвлөмж:** Аудитаар илэрсэн 5340.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Аудитаар материаллаг хэмжээний алдаа зөрчил илэрсэн тул тус байгууллагын санхүүгийн тайланд хязгаарлалтай дүгнэлт өгч, ТТЗ-ын тайлангаар ажилдаа хариуцлагагүй хандсан албан хаагчдад сахилгын шийтгэл ноогдуулах асуудлыг авч үзэх шаардлагатай.

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 11 тоот тогтоолоор 1 м3 халаалтын хөлсийг /НӨАТ/-гүй 1400 төгрөгөөр тогтоосны дагуу "Эрдэс тайга" ХХК-тай дулааны эрчим хүчээр хангах, хэрэглэх тухай 01 тоот гэрээг байгуулсан, гэрээний хугацаа 2020 оны 5-р сарын 1-нд дууссан, гэрээг шинэчлэн байгуулаагүй 2020 оны 12-р сарын 28-нд 02 тоот гэрээгээр 2021 онд нийлүүлэх талаар гэрээг байгуулсан тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1. Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал**

1.1. **Илрүүлэлт:** Тайлант онд мах нийлүүлэх, хүнсний материал худалдан авах тендер зарлаагүй, гэрээ байгуулаагүй компани болон хувь хүнээс мах болон хүнсний материалаа худалдан авч дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

**Эрсдэл:** Холбогдох заавар журамд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүй байх, гэрээ байгуулсан ач холбогдол алдагдах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

1.2. **Өгсөн зөвлөмж:** Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.51-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 6.4.4.хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

**2. Төсвийн хөрөнгийн зарцуулалт**

2.1. Илрүүлэлт: Нярав хүнсний тайлан гаргасан боловч хүнсний материалын зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, нярвын гаргасан тайлан нягтлан бодогч хянасан тайлан 2 зөрүүтэй, хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлж, 5340.2 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэлтэй байна.

Эрсдэл: 1,2. Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, төсвийн үр ашиггүй зардал гарах, холбогдох хууль тогтоомжийг мөрдөхгүй байх

Өгсөн зөвлөмж Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3 "жинхэнэ хэрэгжилтийн", гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

**3. Анхан шатны баримтын бүрдүүлэлт:**

3.1. Илрүүлэлт: Бараа материал худалдан авахдаа И баримтгүйгээр зөвхөн нэхэмжлэл, зарлагын падаанаар орлого авч тайлагнасан зөрчил илэрлээ.

Эрсдэл: Холбогдох хууль тогтоомжийг баримтлах, зардлыг нотлохгүй байх


Өгсөн зөвлөмж Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Иж бүрэн байх зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хуулийн 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, Татварын ерөнхий хуулийн 28.5 “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахим илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**



№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны
---	---------------------------	------------	---------------------------------------	---

			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Тайлант онд мах нийлүүлэх, хүнсний материал худалдан авах тендер зарлаагүй, гэрээ байгуулаагүй компани болон хувь хүнээс мах болон хүнсний материалаа худалдан авч дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй	0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	З.Лхагва Н.Болор-Эрдэнэ
2	Нярав хүнсний тайлан гаргасан боловч хүнсний материалын зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, хүнсний материалыг их хэмжээгээр нөөцөлж, 5340.2 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэлтэй байна.	5340.2	Зөвлөмж өгөх		
3	Бараа материал худалдан авахдаа И баримтгүйгээр зөвхөн нэхэмжлэл, зарлагын падаанаар орлого авч тайлагнасан зөрчил илэрлээ.	0	Зөвлөмж өгөх		
4	Санхүүжилтийн орлогыг бусад орлого гэсэн үзүүлэлтийг сонгосонтой холбоотой 27355,0 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг өсгөн тайлагнасан, Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжин олгосон 2 хүний жирэмсэн амаржсаны тэтгэмж 5074,4 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаагүй байсныг, Үндсэн хөрөнгө актлахдаа дахин үнэлгээний зөрүүг тооцоогүй зөрүү 117.0 мянган төгрөгийг нийт 32546.4 мянган төгрөгийг аудитын явцад залруулга хийгдлээ.	32546.4	Залруулга хийх		
5	Үр дүн, ур чадварын нэмэгдэл илүү олгосон, цалингийн сангаас нэгжийн үнэ олгосон, түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо зарим хүмүүст олгоогүй, НДШ тооцож төлөөгүй, шатахууны зардлыг анхан шатны баримтын бүрдэлгүй шууд зардалд бичиж тайлагнасан, жижүүрлэсэн үеийн цай хоолны мөнгө гаргасан боловч ажилчдадаа олгоогүй, хүнсний материалыг ажилчдадаа өгч суутган тооцоо хийгээгүй, авлагаар бүртгээгүй, шууд зардалд бичсэн зэрэгт 8400.2 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.	8400.2	Төлбөрийн акт		
<b>ДҮН</b>		<b>46286.8</b>			

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

**Х.БОЛДБААТАР**

**Огноо:2021.02.18**

**АУДИТЫН МЕНЕЖЕР**

**А.ЦЭЦЭГСҮРЭН**

**Огноо:2021.02.18**

**АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:**

**ГЭРЭЭТ АУДИТОР**

**Б.БАДАМЦЭЦЭГ**

**Огноо:2021.02.18**